



БИД ЭРДЭНЭДАЛАЙЧУУД

ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙН ЦАХИМ НОМ

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын

Цагаан-Овоо багийн үүх түүх

Түшээт ван, Дайчин бэйсийн хошууны нутгийн зааг (энэ 2 хошууны нутгийн дээс Буйлстын хярын Уул хөтлөөр урагшаа гарч Үнстийн хийдийн зүүн захын 2 худгийн хойд худгийн баруунтаагуур, урд худгийн зүүнтээгүүр орж Булгийг дамжин Хараатын амаар давж зүүн урагшаа даялдаг байв.) нутгийн айл өрхүүдээр бүрдэн 1924 онд Дэлгэрцогт уулын хошуу байгуулагдаж Гучингийн Бага цагаан хараатын баруун урд энгэрт төвлөрчээ. 1927 онд Дэлгэрхангай уулын хошуунд шилжиж 1929 оны 12 сард хийсэн нутгийн захиргааны цомхотголоор татан буугдсан Дэлгэрхангай уулын хошууны Ивгээлт сумынхан болон Дэлгэрцогт уулын хошууны Хөх бүрд сумын баруун талынхантай нийлж томрон төвөө Үнэстийн хийдэд аваачин төвхнөжээ. 1931 онд хошуудыг татан буулгаж аймгуудыг байгуулахад Өмнөговь аймгийн харъяанд очоод 1932 онд Төв аймгийн, улмаар 1942 онд Дундговь аймаг байгуулахад тус аймгийн сум болжээ. 1933 оны байдлаар есөн баг 376 өрх 1600 хүн ам, 50,6 мянган малтай байв.

1959 онд зүүн хойд талын 2 багийнхан нь шинээр байгуулагдсан Хонгор суманд шилжиж, олон жижиг нэгдлийг нэгтгэн томсгох үйл явцын үед 1961 оны 9-р сард татан буугдаж бүхлээрээ шилжиж Эрдэнэдалай сумтай нэгдсэн юм.

Энэ үед тус сум 148,111 га нутагтай, 220 өрхийн 871 хүн ам, 39,094 толгой малтай байжээ. Одоогоор манай баг нь 151,115.6 га нутагтай 236 өрхийн 847 хүн ам, 107,382 толгой малтай байна.

Цагаан-Овоо сум татан буугдаж баг бригад болон өөрчлөгдөж даргаар нь ажиллаж байсан хүмүүс: Сугирын Баяндэлгэр, Аюурын Ожоо, Сугирын Баяндэлгэр, Дэлэгийн Батцэрэн, Балданхундагын Цэвээндорж, Дэлэгийн Батцэрэн, Даваажавын Цэгмэд, Цэрэндоржийн Дагва, Бямбын Сугир, Дугарсүрэнгийн Ганболд, Жанцанхоролын Сосорбурам, Намчинжавын Чулуун, Баяраагийн Сумъяадорж, Мөнхболдын Насанбаатар, Доржийн Ууганбаяр нар, **ня-бо тоо бүртгэгчээр:** А.Ожоо, Ц.Шар, Д.Цэгмэд, Д.Ганболд, Төмөрдагва нар, **аж ахуйгаар:** Б.Дүгэр, З.Нанчинжав, Г.Ганхүү, М.Загдаа нар, **агентаар:** Т.Даваажав, Д.Өлзийхутаг, А.Ожоо, Л.Пүрэв, С.Лхагва нар, **малын эмчээр:** С.Жамба, Д.Жигмэджамц, Т.Цогзолмаа, О.Буянбаатар, Д.Пагмадулам нар, **хүний эмчээр:** Ц.Дашдолгор, Г.Ууганбаяр нар, **түүхий эдийн эрхлэгчээр:** Б.Цэвээндорж, **мал зүйчээр:** Ө.Лхагва /1977-1979/, Б.Мягмаржав, Д.Батцэрэн, Алинчбиш нар, **хэсгийн ахлагчаар:** Д.Цэгмэд, Ж.Бямба, Цэр.Цэрэндорж, Ц.Баяраа, О.Цэрэн-Очир, Л.Пүрэв нар, **хэвлэл түгээгчээр:** Павай, Санзайдорж, П.Лхагва нар тус тус ажиллаж байсан байна. Цагаан-Овоо бригадын хамт олны 1986 оны зураг: Ар талын баруун талаас

1. Зоотехникч Сугирдоржийн Алинчбиш

2. Нягтлан бодогч Даваажавын Цэгмэд
3. Малчин Даржаагийн Нүрдэв
4. Намын хэсгийн ахлагч Балданпунцагийн Цэвээндорж
5. Бригадын дарга Бямбаагийн Сугир
6. Жолооч Балдангийн Алтангэрэл
7. Хөдөлмөрийн баатар Цэрэндоржийн Дагва
8. Хэсгийн ахлагч Ламзавын Пүрэв
9. Бригадын намын дарга Сугирын Баяндэлгэр
10. Аж ахуйн нярав Гэндэнгийн Ганхүү
11. Агент Цэрэндоржийн Эрдэнэ-Очир
12. Хэсгийн ахлагч Ожоогийн Цэрэн-Очир
13. Хэсгийн ахлагч Цэгмэдийн Баяраа
14. Малын эмч Лхамсүрэнгийн Сугиржин
15. Түүхий эдийн салбарын ажилтан Содномдаржаагийн Лхагва
16. Хүний бага эмч Цэрэнчимэдийн Дашдолгор
17. Түүхий эдийн эрхлэгч Дэмбэрэлийн Батбилэг
18. Бригадын үйлчлэгч Дуламжавын Цэнд
19. Малчин Балдандоржийн Долгорсүрэн
20. Хэсгийн ахлагч Дугарсүрэнгийн Ганболд нар юм. Үүнд зураг авхуулж амжаагүй малын эмч Равдангийн Машбат, Доржийн Жигмэджамц нар байгаа.





Цагаан-Овоо багийн малчдын дотроос Хөдөлмөрийн баатар Ц.Дагва /1980/, Улсын аварга малчид О.Лхамсүрэн /1966/, Ц.Дагва 1982/, Ц.Цэрэндорж /1986/, Су. Мөнхбаяр /1987/, С. Баатардорж /1989/, Д.Цогтбаяр /1988/, М.Галбадрах /2019/, Ц.Мөнхбаяр /2022/ , Аймгийн аварга малчид: Ц.Дагва /1967, 1980, 1986/, Д.Нүрдэв /1972/, Ц.Цэрэндорж /1977, 1982, 1989/, С.Мөнхбаяр /1976, 1983, 1990/, С.Баатардорж /1987/, Р.Содномпэл /1983/, Д.Цогтбаяр/1987/, Улсын залуу аварга малчин Л.Бизъяа /1986/ нар, Улсын алдарт уяач Д.Цогтбаяр, аймгийн аварга малчин: Мө.Гантулга /2006/, Л.Өсөхбаяр, П.Баттогтох /2022/, Д.Энхбаатар /2022/, Б.Цогдорж /2022/, Б.Мөнх-Од /2022/, Ч.Энхтүвшин /2023/, Аймгийн алдарт уяач Н.Хүрэлтогоо /2002/, Ё.Батнасан 2013/, М.Галбадрах, Д.Сумъяасүрэн , Д.Хаянхярваа /2010/, О.Ундрахбаяр /2020/, Н.Отгонбат /2020/ нар тус тус болсон байна..

Үнстийн хийд

Эрдэнэдалай сумын төвөөс урагшаа 35 км, Нүүрсний уурхайгаас зүүн хойш 5 км-т туурь нь байдаг.

Үнстийн хийдийг анх Цэвэг ламтан Төвдөд их номыг үзээд тэр нутгаас буцахдаа өөрийн багшдаа бараалхаж ар халх буюу нутагтаа очиж хийд байгуулах санаагаа хэлж сахиус хайрлахыг хүссэн байна. Гэтэл багш нь чиний энэ их сайн хэрэг байна. Тэр байгуулах хийдийн шүтээнийг нь одоо биш хожим чамд үзүүлнэ гэж багш нь хэлжээ. Цэвэг ламтан тэндээс явж нутгийн дээс алхаад нэгэн хадан цохионы өвөрт хавчиг үүргээ задлан цайгаа чанаж суутаямар нэгэн юм тор хийх чимээнээр дээшээ хартал хадан цохионы оройд өлгөгдсөн танх бурхан салхинд хийсэж байна гэнэ. Авч үзтэл Гомбо сахиус байсан гэдэг. Лам ихэд билэгшээн энэ багшийн минь илгээсэн сахиус мөн хэмээн адислан эвхэж үүргэвчиндээ залж явсаар одоогийн Үнстийн хийд байгаа газарт ирвэл хэдэн ямаатай нэгэн ядмагхан чавганцых байжээ. Цэвэг ламтан тэр айлд орж мэнд усаа мэдэлцэн хэрэг зоригоо ярьтал чавганц энүүхэн зүүнтээ манай үнс асгадаг газрын хэдэн чулуун дээр хэрээ их цуглардаг юм. Ламтан болгоовол тэр газрыг очиж үзэхгүй юу гэснээр очиж хартал үнэхээр хэл үгтэй хэрээ цугласан энэ газар хурал номын хийд байгуулахад зохимжтой хэмээн шинжиж уг орон хийдээ байгуулсан түүхтэй. Гомбо сахиусын гол амьтан нь хэрээ билээ. Энэ домгоос үүдэн сүсэгтэн олонд Хэрээ үнстийн

хийд, Үнстий цагаановооны хийд гэж газар нутгийнхаа нэрээр алдаршсан юм. 1808 оны шар луу жил Цэвэг гавж гэгч хүн санаачлан байгуулж 1915 оноос дэгжиж хөгжжээ. Үнэстий гэж нэрлэсэн бас нэг хувилбар нь ойр орчмын байдлаар бус дээр үед шатаж нэрвэгдсэний ор туурь дээр сэргээн байгуулагдсанаас тийн нэрлэсэн гэсэн аман яриа бас бий. Манжийн Бадаргуулт хааны үед зэргэлдээх Сангийндалай хийдийг салар хуйхуй гээчийн үймээнээр шатааж түйвээсэн гэж уг хийдийн түүхэнд гарч байгаа болон урьд шатаж нэрвэгдсэний туурь дээр сэргээн байгуулагдсанаас Үнстий хэмээн нэрлэсэн гэх аман яриа хоёрыг холбож бодоход Сангийндалайн хийдийг түйвээгч салар хуйхуй гэгчийн хөлд нэрвэгдсэн байж болох юм. Энэ хийдийг Монголын өмнөд нутгийн хийдийн зохион байгуулалтаар төв сүмүүдийг зүүн баруун тийшээ эгнүүлэн урагшаа харуулж барьж гол дунд нь Цогчин дуганыг өмнө нь барилга байшингүй барьж цогцлоожээ. Сүмүүдийг ямба ёслолын хаалгагүй, хэрэмгүй, бие даасан байдлаар барьсан байна. 1937-1938 оны байдлаар 320 орчим ламтай, Цамгүй Тантрын шүтлэггүй, Дэмчиг, Дүйнхорын дацантай. Эндхийн гол баяр ёслол нь Цагаан сар, Майдар эргэх байв. Хийдийн 4-н талд горлом дээр нь “Майдрын овоо” хэмээн нэрлэсэн тус бүр бяцхан суваргатай, майдар эргэхэд тэдгээрийн дэргэд үдэлдэг байлаа. Энэ хийдэд дээр дурьдсанаас гадна Цогчин, Ламиран, Майдар, Дарь эх, Манала, Чойр, Дордовын сүмүүд, Цогчин дуганы ард маанийн 2 том хүрд, Зүүн талд нь нэг эгнээ зургаан том Суварга байжээ. Лам нарын сууц хувийн шүтээний барилга байшин дугануудын баруун зүүн талаар эгнүүлэн байршуулсан нь одоо ч тодорхой бий. Чойрын дуганыг цагаан тойн хэмээх хүн модыг худалдан авч бариулж байсан байна. Цагаан тойн буюу Чимэддорж гэгч хүний удам хойч үе нь одоо Ожоогийнхон гэж олон гэр бүлүүд байдаг. Цогчин дуганыг 1916 оны улаан луу жил барьж эхлүүлэх ажлыг Балдандоржийнхны дээд удам Жигжид дооромбо хэмээх хүн хийж 1918 онд ашиглалтанд оруулж байжээ.

Энэ хийдийн сүүлчийн ловон, цорж Увшийн Жигжид /1863-1937/ хэмээх Да лам байв. Тэрээр 16 насандаа Онгийн голын баруун хийдэд шавилан сууж байгаад Их Хүрээнээ очиж Гандантэгчилэн хийдэд 1889 онд домын дамжаа барьж цагагчин туулай жил /1891 он/ Түвдэд очиж Бэрээвэн хийдэд сууж Дооромбо болж 1902 онд нутагтаа ирж энэ хийдийг тэргүүлж байгаад 1937 онд баривчлагдаж Улаанбаатарт хүргэгдээд байцаагдахаар туугдаж явахдаа нутгийн өөр нэг эрдэмт ламтай хоёул өөд өөдөөсөө харж тасга авч 2 биенийхээ поог түлхэн бодь мөрийн замдаа одсон гэдэг яриа бий. Уран барилгын ховор хийц бүтээцийн нандин дурсгал энэ Цогчин дугана улсын хамгаалалтанд байгаа боловч он цагийн элээлт хайхрамжгүй хүмүүсийн хэнэггүй байдлаас ихээхэн муудаж устах аюулд ороод байна.





Үнстийн Цагаан-Овоо

Эрдэнэдалай сумын 5-р багийн нутаг Үнстий хийд хэмээх газар орших энэ овоо нь аймгийн төвөөс 10 км сумын төвөөс 36 км зайд оршино. Үнстийн хийдтэй салшгүй холбоотой энэ хайрханыг эртнээс тахиж ирсэн бөгөөд 1990 онд Цагаан-Овоо бригад, Сугир тэргүүтэй хүмүүс тахилгыг сэргээж, 1998 онд Цагаан-Овоо багийн иргэн Балдандоржийн Адьяа анх Цагаан-Овооны ураг удмыг судалгаа хийн, тогтоож ургийн бичгийг айл бүрт хийж өгсөн байдаг. 2005 оноос “Тайжийн бүргэдүүд” овгийн Ожоогийн Цэрэн-Очир тэргүүтэй хүмүүс анхлан ураг удмаараа тахих санаачлагыг гарган тахиж эхэлсэн. Үүнээс хойш Баяжих, Мянгат, Залан, Мэнгэт, Тойныхон, Олхонууд, Үнстий, Үнстэй зэрэг овгийнхон ураг удмаараа жил бүрийн зуны адаг сарын шинийн 05-нд овоо тахилгыг ургийн баяртайгаа хамтатган тахиж хэвшсэн. Тэрхүү анхны Гомбо сахиус одоо Цагаановоо багийн малчин Сумьяасүрэнгийн Хатанбаатарт хадгалагдаж байдаг. С.Хатанбаатарын өвөө Жаламын Буяндэлгэр уг хийдэд шавьлан сууж байсан бөгөөд үймээн самууны үеэр багш нь түүнд сахиусыг энх цагт гаргаж ирээрэй гээд өгчээ. Тэрээр энэхүү сахиусыг 2 нимгэн ширдэг хийгээд дунд нь хийж оёод хадгалж байгаад 1990 онд гаргаж ирсэн гэдэг. Ийнхүү Үнстийн хийд байгуулагдснаар домогт Цагаан-Овоог тахилгат овоо болгон тахилгын сахиус нь Гомбо сахиус болсон ба уг уламжлалт зан үйлийг 1991 оноос сэргээн ураг, удмаараа тахидаг уламжлалыг бий болгоод 32 дахь жилдээ золгож байна.

2009 онд хэвлэгдэн гарсан “Монголын сүм хийдийн түүхэн товчоон” , мөн 2019 онд хэвлэгдсэн “Луусын хийд” , 2011 он “Дундговь аймгийн толь” номуудад “Үнэстийн хийд”-ийн ламаар

1918 оноос хойш 20 шахам жил эрдэмт лам ловон Жигмэд Дооромбо гуайтай хамт их номын үйл бүтээж байсан оточ маарамба, гэвш Гэндэндаржаагийн Болд гэдэг хүн Цагаан – Овоогийн хийдэд мөрөө үлдээсэн томоохон лам нарын нэг яавч мөн.


Г.Болд хийдийг тарах хүртэл авч явсан төдийгүй олон талын чадалтай лам байжээ. Г.Болд 1875 онд Түшээт хан аймгийн Дайчин Бээсийн хошуу одоогийн Эрдэнэдалай сумын Цагаан –Овоо багийн нутагт төрж, хүүхэд ахуйдаа өнчирч, бага наснаасаа хүрээ хийд бараадаж , 10 орчим насандаа Богдын хүрээнд сууж, ном үзэж, шашны ёсоор оточ маарамба, гэвш цол хүртжээ.

Тэрээр багшийнхаа гавьжийн дамжаа барих шаардлагаас цаараглаж, 1917 оны Октябрийн хувьсгалын нөлөөг тунгаан, нутагтаа очиж ном, буяны ажил хийе гэж багшаасаа гуйсаар хөдөөлсөн хүн юм. Тэгээд дээрх хийдэд сууж буян хийсэн , их эрдэмтэй лам гэж алдаршсан, “Болоо гэлэн”, “ Бандгай ” нэрээр хүндлэгдсэн нэгэн ухаантан байсан нь ийнхүү түүх болон үлджээ.

Энэ ламтан 1957 онд 82 насандаа тааваараа мөнх бусыг үзэж жанч халжээ.

Цагаан-Овоог тахигдаа

Үнстийн Цагаан-Овоо /их тахилгат овоо/-ны тахилга наадам дээр үеэсээ зуны адаг сарын шинийн таванд болдог ба тухайн өдрийн өглөө овооны дөрвөн талд ном уншиж, нэг үхэр, зургаан хониор шүүс тавьдаг. Тойрсон хэдэн сумын хурдан морь, хүчит бөхчүүд ирж барилддаг өргөн дэлгэр наадам болдог уламжлалтай.



Хөөрөгний толгой шиг товойсон
Хөөрхөн төмбөгөр цагаановоогоо
Алсын алсад цайрах
Алтайн уулнаас өндөрт боддог би...

П.Төмөрбаатар

Домог өгүүлрүүн:

Цагаан-Овооны зүүн суганаас бяцхан булаг ундрэн зүүн урагшаа жирэлзэн урсаж нэг км хэртэйд орших тойромд цутгана. Булгаас зүүхэнтээ оорцог ганц улаан овоо хөөрөгний шүрэн толгой шиг шовойно. Түүний зүүнтэй тэвхийх чинээлэг айлын утаа зуусан бор авдар шиг дөрвөлжин хүрэн уулыг “Баян улаан” гэнэ. Харсан бүхний сэтгэл хөвөлзөн татагдавч халдаж чадахгүй халгадаг сүртэй хэрнээ үзэсгэлэн төгс, хүндэтгэлтэй хүүхэн /Цагаан-Овоо/ түүний нөхөр түвшин гүндүүгүй, түшиг нөмөртэй налгар эр /Баян улаан/, тэр хоёрын хүүхэд номонд гэгээрч байгаа банди /Улаан толгой/, урсгал ялдам эрх танхи охин /Булаг/, бондгор бор хөвүүн /бор толгой/ энэ бүгд нэгэн халуун ам бүл гэсэн домогтой.

Бас нэгэн шинжээч хүн Цагаановоог луу шинжтэй хүчирхэг газар, энд амьдарсан хүмүүн сайн сайхан, элбэг дэлбэг амьдарна гэжээ. Овооны зүүн талын хүрэн уул /баян улаан/- луугийн толгой, цагаановоогоос урагших булаг бол –луугийн нүд, овооноос баруун тийшхи 2 өндөр улаан толгой бол- луугийн хоёр бөх, баруун урагш байрлах одоогийн Оюут уурхай хэсэг бол - луугийн баруун хөл орчим юм. Тийнхүү баруун сарвуундаа эрдэнийн чулуу атгасан луу хэлбэрийн газар хэмээн үзжээ.

Миний нутгийн овоо дуу

Үг: Ш.Сарантуяа

Ая: Г.Эрдэнэчулуун /МУСТА/

Алсын газраас хүрээд очиход
Аав ээжийн минь гэр шиг санагдана
Алаг дэлхийн сувдан сондор
Ачлан хайрлах өлгий нутаг минь

Дахилт: Ард олны минь нандин холбоо

Аялгуу хөгөлсөн цэнхэр нутаг аа

Сүүгээн өргөх ээжийн эрдэнэ
Саруул дэнжийн мөнгөн аяга
Санан санан дурсан суухад
Санаанд ганцхан цагаан овоо минь

Дахилт: Ард олны минь нандин холбоо
Аялгуу хөгөлсөн цэнхэр нутаг аа
Цэнхэр тэнгэртээ өргөсөн цацал
Цэнгүүн талын мөнгөн зулай
Цагийн цагтаа үлдсэн овоо минь
Цаглашгүй орчлондоо мөнхөрсөн нутаг аа

Дахилт: Ард олны минь нандин холбоо
Аялгуу хөгөлсөн цэнхэр нутаг аа
Өвөг дээдсийн минь ариун шүтээн
Өссөн бидний өлгий нутаг минь
Өлмий дор чинь залбиран мөргөж
Өнөд танийгаа дээдэлж явья аа

Дахилт: Ард олны минь нандин холбоо
Аялгуу хөгөлсөн элгэн говь оо





ХАН ДЭЭЖ ХХК ТОВЧ Танилцуулга

“Хан Дээж ХХК” нь 1997 онд Уул уурхайн ашиглалт, үйлдвэрлэлийн чиглэлээр дотоодын хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан. 2014 оноос эхлэн гумин

болон фульво хүчилд суурилсан эх орны түүхий эдээр үйлдвэрлэсэн, органик гаралтай “Шимт бор” шингэн бордоо “Тэжээлт бор” малын шингэн эрдэс тэжээл үйлдвэрлэх туршилт судалгааны ажлыг Монгол, Унгар, БНХАУ-ын эрдэмтэдтэй хамтран эхлүүлсэн. Тус шингэн бордоо, малын тэжээлийг 2019оноос эхлэн Дундговь, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Архангай болон Дорнод аймгийн бүс бүсийн газар тариалангийн компани, малчин өрх хувь хүн өргөнөөр хэрэглэж, бодит үр дүн гарсаар байна. Мөн 2022 оноос эхлэн ХБНГУ-н гумин болон фульво хүчлээр малын тэжээл үйлдвэрлэдэг компанитай хамтран ажиллаж евро стандартад нийцсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнээр антибиотикийн хэрэглээг халж малын дархлааг нэмэгдүүлэн малын өвчнийг анагааж, шим тэжээлийг дутагдлыг нөхөх зориулалтай малд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Монгол орныхоо бүтээн байгуулалтын салбарт үр бүтээлтэй ажилласан, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг төрөөс үнэлэн тус компанийн захирал Жүгдэрноров овогтой Баярхүүг Үйлдвэр, Худалдааны яамны Жуух бичиг, салбарын шагнал “Тэргүүний уурхайчин”, төрийн дээд шагнал “Алтан гадас” одон, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор Мөн 2022 онд Монголын хэрэглэгчдийн удирдлагын академийн онцгой бүтээлийн АКАДЕМИЧ цолоор тус тус шагнасан байна

Тус компанийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнүүд нь Монгол улсынхаа хөгжил цэцэглэлтэд үнэтэй хувь нэмэр оруулж Уул уурхай, Мал аж ахуй, Газар тариалангийн салбарт, монгол малыг эрүүлжүүлж, нэгжээс авах бүтээгдэхүүний чанар хэмжээг нэмэгдүүлж байгаагаас гадна газар тариалан хүнсний ногоо, мод үржүүлгийн газрыг цэвэр байгалийн бордоогоор хангаж байгаа зэрэг эх орныхоо ирээдүйн хөгжилд юугаар ч үнэлшгүй хувь нэмэр оруулж байгаа билээ.



会副理事
现在是省
品远销欧
肥料增效。
医药及生物
生产线配套
完成总工
战略合作意
万美元)，利



Камер
ажиллаж
байна

ТЭЖЭЭЛТ БОР МАЛЫН ЭРДЭС ТЭЖЭЭЛТ
ТЭЖЭЭЛТ БОР (ТБ) малын эрдэс тэжээл нь ургамалын эдийн хувь
хялбаршуулж гаргасан өвсний (фурма, гүмүүн хүч) агуулгатай байгалийн гар
болон хайрвал урсгалт тэжээл юм.
болон үр ашигтай эрдэс тэжээл юм.
ТЭЖЭЭЛТ БОР малын эрдэс тэжээл нь бакалтийн орчин хүрээний илэрхий, байгалийн орчин эрдэс бүхий мал амьтны өсөн тогтолцоог тэтгэх, тэмдэг тэжээл, дархлааны урсгал
эсрүүтэй, далай малын чандир сайжруулах, хорьт гаднагуулах, гэгээний гурвалзах хөдөлгөөнийг багасгах чадвартай тэжээл юм. Гүмүүнэд эдийн хувьтай тэжээл, гүмүүнэд эдийн хувьтай тэжээл,
урьтмал сүрьеэ, борлон гэрэлтүүлэх урсгалт тэжээл, жолоо үр тэжээл, амьдрах чадаргүй болон өмгүүг үнэгдэх үрэг хунар хэзээ урьдчилан сэргийлж боломжтой юм.
Мал амьтны сэтгэж үеийг эрдэс тэжээлээр хангах (фурма, гүмүүн хүч) агуулгаас гадна калси, агри, калси, тэмдэг, шилтэй, 4% гэм 74 эрдэс болон, 10 витамин,
Найрвэл: Урсгалт орчин болон ургамалын эдийн хувьтай тэжээл, амьдрах чадаргүй болон өмгүүг үнэгдэх үрэг хунар хэзээ урьдчилан сэргийлж боломжтой юм.
18 амьтны бие засвартай малын бие засвартай амьтны хэргээр агуулахаар.
Хэрэглэх арга тус:
1. ТЭЖЭЭЛТ БОР эрдэс тэжээлийг БОГ МАЛ (АДУХ, УХСР, ТЭМЭЭ) -д өдөр амьтны жингийн 0.1кг/кг-аар болон 30 хоног өгсний дараа 10 хоног завсарлаж урсгалжүүлж өгнө.
2. ТЭЖЭЭЛТ БОР эрдэс тэжээлийг БОГ МАЛ (АДУХ, УХСР, ТЭМЭЭ) -д өдөр амьтны жингийн 0.09мл/кг-аар болон 30 хоног өгсний дараа 10 хоног завсарлаж урсгалжүүлж өгнө.
3. Шилтэй тэжээлийг үрэгдэх үеийн 12 цагийн дотор урсгалж өгнө.
ТЭЖЭЭЛТ БОР малын эрдэс тэжээл нь дээрхүү болон өөр өөрөөр агуулахаар. Малын бүх төрлийн өвчин, бактер, ви
Хэргийг малыг хуураартай өвчин амьтны жингийн 0.1кг тутамд бол мал 0.12мл, бөгөөд мал 0.09мл-аар болон 25-30
дараа урсгалжүүлж өгнө. Гэхдээ 4 сар болон 10 хоног завсарлаж урсгалжүүлж өгнө. Нэгж 4 сар болон 10 хоног завсарлаж урсгалжүүлж өгнө.
Өвчин амьтны малын бие засвартай малын бие засвартай амьтны хэргээр агуулахаар. Малын бүх төрлийн өвчин, бактер, ви
Боловсролын амьтны жингийн 1кг тутамд 0.1кг, бөгөөд мал 0.09мл-аар болон 25-30 хоног өгсний дараа 10 хоног завсарлаж урсгалжүүлж өгнө.

